



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 07 өдөр

Дугаар А/590.

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн “а”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 78 дугаар зүйлийн 78.2.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цэцэрлэгийн барилга, 240 ор /Ховд, Жаргалант сум, 9 дүгээр цэцэрлэг/ -н барилга угсралтын ажлын тоо хэмжээнээс гадна нэмэлтээр хийгдсэн ажлыг нягтлан шалгаж нэмэлт гэрээ байгуулан санхүүжилтийг шийдвэрлэх боломжтой эсэх талаар шийдвэр гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Баярсүх - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд:

Н.Ганзориг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрхзүйн хэлтсийн дарга

А.Жамъяансүрэн - Мэргэжлийн хяналтын газрын хэлтсийн дарга, Улсын ахлах байцаагч

Б.Түмэндэмбэрэл - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Н.Тодбаяр - 9 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч

Ц.Гансүх - “Ганбүрэн”ХХК-ний захирал

- Зах А/590 Чх
02 02638

Нарийн бичгийн
дарга: Д.Тогтохбаяр

-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын Барилга хот байгуулалтын
хэлтсийн ахлах мэргэжилтэн

2. Тус ажлыг шийдвэрлэх боломжтой эсэх талаар ажлын хэсгийн дүгнэлтийг
2020 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн дотор багтаан гаргаж ажиллахыг ажлын
хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН